



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 110


Улаанбаатар хот

┌ Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны ... сарын ... өдрийн
№...-р тогтоолын хавсралт



“МОНРЕ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг
1	Р.Туяацэцэг /УУ56071002/	2,655,561	2,655,561,000.00	53.11%	(2,655,561)	-	2,655,561,000.00	-
2	У.Сийлэн /ЧК80090709/	1,768,866	1,768,866,000.00	35.38%	2,655,561	2,655,561,000.00	-	4,424,427
3	П.Эрдэнэбаатар /ЧК87020712/	575,573	575,573,000.00	11.51%	-	-	-	575,573
	Нийт	5,000,000	5,000,000,000.00	100%	-	2,655,561,000.00	2,655,561,000.00	5,000,000